

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Газрын зургийг зохиох, зурах, хэвлэх, судлах, ашиглах аргазүйн шинжлэх ухааныг гэнэ. /1оноо/

- A. Топографи
- B. Гипсографи
- C. Гигрографи
- D. Картографи
- E. Барографи

2. Газрын гадарга орчимд усны уур конденсацид орж жижиг усан дусал, мөсөн талстууд үүсэн алсын бараа 1 км-ээс илүүгүй харагддаг үзэгдэл аль нь вэ? /1оноо/


- A. Шуурга
- B. Манан
- C. Униар
- D. Хур бороо
- E. Шүүдэр

3. Гэрлийн жил юуны нэгж вэ? /1оноо/

- A. Энергийн
- B. Даралтын
- C. Эзлэхүүний
- D. Зайн
- E. Дулааны

4. Урианхай ястан аль аймагт амьдардаг вэ? /1оноо/

- A. Баян-Өлгий
- B. Говь-Алтай
- C. Увс
- D. Завхан
- E. Ховд



5. Гарал үүслээрээ ижил, олон тооны бүлэг арлуудыг юу гэж нэрлэдэг вэ? /1оноо/


- A. Олтриг
- B. Садраа
- C. Бага газар
- D. Бүлэг газар
- E. Ооз

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- 1) 2.1 даалгаврын Завхан голын усны зарцуулалтыг [a,b,c], Орхон голын усны зарцуулалтыг [d,e,f], сонгосон хариултаа [g] эгнээнд тэмдэглээрэй.
Жишээлбэл:эцсийн хариуг Завхан -173, Орхон -205, Зөв хариултаас 4 дугаарыг сонгосон гэж үзвэл a-1, b-7, c-3, d-2, e-0, f-5, g-4 гэж бөглөнө.
- 2) 2.4-р даалгаврын хариуг авахдаа таслалаас хойших нэг оронг тооцно.
Жишээлбэл:эцсийн хариуг 1.9 гарсан гэж үзвэл [a – 1] [b - ,] [c – 9] гэж бөглөнө.
- 2.1. Завхан голын өргөн 25 м, хамгийн гүн 2.8 м, урсгалын дундаж хурд 2.4 м/с болно. Орхон голын өргөн 45 м, хамгийн гүн 3.5 м, урсгалын дундаж хурд 2.2 м/с болно. Хоёр голын усны зарцуулалтыг тооцоолж, алийг нь томоохон уулын баяжуулах үйлдвэрт ашиглах боломжтойг сонгоно уу. /4оноо/
1. Эрхэт хайрханаас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгадаг Орхон гол
 2. Ханхөхийн нуруунаас эх авч Хяргас нуурт цутгадаг Завхан гол
 3. Тарвагатайн нуруунаас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгадаг Орхон гол
 4. Хангай нуруунаас эх авч Айраг нуурт цутгадаг Завхан гол
- 2.2. Жолоочид 2 тн ачааг 50 км зайд тээвэрлэх ажлын санал иржээ. Жолооч захиалагчтай 1 тн км ачаа эргэлтийг 1000 төгрөгөөр тээвэрлэхээр тохиролцжээ. 2 тн даацтай Портер машин нь 100 км-т 13 л түлш зарцуулдаг бөгөөд зах зээлийн ханшаар 1 л түлш нь 1780 төгрөг бол жолоочид оногдох цэвэр ашгийг тооцоолж олоорой. /4оноо/
- 2.3. Дууны долгион усны гадаргаас ёроол хүрээд буцаж ирсэн хугацаа 6 сек байсан бол тэнгисийн гүнийг тооцоолж гаргаарай. /4оноо/
- 2.4. АНУ 2015 оны байдлаар 314 сая хүн амтай. Хэрэв хүн ам нь 2025 онд 358 саяд хүрэх бол хүн амын жилийн дундаж өсөлтийг тооцоолж олоорой. /4оноо/

6. Викингүүдийн (Нормандын Л.Эриксон) нээсэн газар нутаг аль нь вэ? /1оноо/
- А. Антарктид, Россын тэнгис
 - В. Австрали, Номхон далайн арлууд
 - С. Лабрадор, Ньюфаундленд, Гренланд
 - Д. Полинезийн арлууд, Филиппиний олтриг
 - Е. Баффины газар, Антилийн арлууд
7. Арктикийн газрын зургийг зохиоход аль тусгагийг ашиглавал хамгийн бага гажилттай зурагдах вэ? /1оноо/
- А. Цилиндр
 - В. Азимут
 - С. Конус
 - Д. Хөндлөн азимут
 - Е. Огтолсон конус
8. Эх газрыг ойролцоох арлуудын хамт юу гэж нэрлэх вэ? /1оноо/
- А. Хойг
 - В. Тив
 - С. Арал
 - Д. Олтриг
 - Е. Хошуу
9. Хөвсгөл аймгийн голууд аль далайн ай савд багтах вэ? /1оноо/



- А. Номхон далай ба Хойд мөсөн далайн ай сав
- В. Хойд мөсөн далай ба Гадагш урсгалгүй ай сав
- С. Энэтхэгийн далай ба Хойд мөсөн далайн ай сав
- Д. Гадагш урсгалгүй ай сав ба Энэтхэгийн далайн ай сав
- Е. Номхон далай ба Гадагш урсгалгүй дотоодын ай сав

10. Өндрийн хэлбэлзэл 200 м-ээс хэтрэхгүй, хэвгий багатай гадаргын харьцангуй тэгш хэлбэрийг юу гэж нэрлэх вэ? /1оноо/
- A. Бэгэлцэг
B. Тэгш өндөрлөг
C. Нам газар
D. Тал
E. Мөргөцөг
11. Улаанбаатар хотоос шууд нислэг хийдэг хотыг сонгоно уу. /1оноо/
- A. Берлин
B. Кайр
C. Дели
D. Жакарта
E. Ханой
12. Голын голдрилын тахирлалтыг гэнэ. /1оноо/
- A. Татам
B. Дэнж
C. Голдрил
D. Меандр
E. Дельта
13. Эрэг ба нуурын хооронд хоногоор чиглэлээ өөрчилдөг салхи аль нь вэ? /1оноо/
- A. Баруун зүг
B. Пассат
C. Муссон
D. Фён
E. Бриз
14. Наранцэцэгийн ургац хураалтаар дэлхийд тэргүүлдэг улсуудыг олоорой. /1оноо/
- A. АНУ, Мексик
B. Украин, ОХУ
C. Аргентин, Бразил
D. Хятад, Энэтхэг
E. Польш, Беларусь
15. Дэлхийн бөмбөрцөгийн хойд хагаст нар эгц тусдаг шугам аль нь вэ? /1оноо/
- A. Туйлийн цагираг
B. Мэлхийн зам
C. Дундаж өргөрөг
D. Туйл
E. Матарын зам

47. Тосон Хулстайн байгалийн нөөц газар нь хэдэн аймгийн нутгийг дамнан оршдог вэ? /2оноо/
- A. Хэнтий, Дундговь
B. Дорноговь, Сүхбаатар
C. Дундговь, Дорноговь
D. Хэнтий, Дорнод
E. Дорнод, Сүхбаатар
48. Чи Лондонгийн Их Сургуульд засгийн газрын тэтгэлгээр суралцах эрх авсан гэж бодъё. Тухайн сургуулийн сургалтын менежерээс Лондонгийн цагаар өглөөний 9 цагт утсаар холбогдоно уу гэсэн зурвас хүлээн авсан бол Улаанбаатарын цагаар хэдэн цагт холбогдох вэ? /2оноо/
- A. 14 цаг
B. 15 цаг
C. 16 цаг
D. 18 цаг
E. 16 цаг
49. Африкийн газар усны нэрсийг хойноос урагш нь зөв байрлуулсныг сонгоорой. /2оноо/
- A. Виктори нуур, Сахарын цөл, Луугийн уулс
B. Нигер мөрөн, Сомалийн хойг, Чад нуур
C. Атласын нуруу, Сахелийн цөл, Ливингстоны хүрхрээ
D. Намибын цөл, Замбези мөрөн, Танганьика нуур
E. Камерун галт уул, Конго мөрөн, Рудольф нуур
50. Монгол орны усны сав газруудыг аймагтай нь харгалзуулаарай. /4оноо/
- | | |
|--------------------|---|
| 1. Орхон | а. Булган, Хөвсгөл |
| 2. Сэлэнгэ | б. Хэнтий, Төв, Сэлэнгэ |
| 3. Эг-Хөвсгөл нуур | в. Булган, Архангай |
| 4. Ерөө | г. Хөвсгөл, Булган, Сэлэнгэ |
| 5. Хануй | д. Төв, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Архангай |
- A. 1-г, 2-в, 3-б, 4-д, 5-а
B. 1-д, 2-г, 3-а, 4-б, 5-в
C. 1-а, 2-в, 3-г, 4-д, 5-б
D. 1-д, 2-а, 3-г, 4-б, 5-в
E. 1-в, 2-а, 3-д, 4-б, 5-г

42. БНХАУ-ын Шинжаан-Уйгур ба Өвөр Монголын ӨЗО, Ганьсү мужтай хиллэдэг аймаг, хилийн гарцыг сонгоорой. /2оноо/

- A. Ховд, Булган
- B. Баян-Өлгий, Цагааннуур
- C. Увс, Боршоо
- D. Говь-Алтай, Бургастай
- E. Өмнөговь, Шивээхүрэн

43. “Хөрсний алдагдлыг тооцох нэгдсэн томъёо” нь жилийн дундаж хөрсний зөөгдлийг тн/га нэгжээр хэмждэг бол L нь юуг илэрхийлдэг вэ? /2оноо/

- A. Хөрс хамгаалал
- B. Гадаргын өөрчлөлт
- C. Налуугийн градиент
- D. Хөрсний элэгдэх шинж
- E. Хажуугийн урт


A=RKLSCP

44. АНУ-ын Вашингтон хотод төвтэй 1944 онд Бретон Вудэд байгуулагдсан олон улсын байгууллага аль нь вэ? Энэ байгууллагад Монгол улс 1991 онд элссэнээс хойш валютын зах зээлийн тогтвортой байдал болон мөнгө санхүү зээлийн талаар дэмжлэг туслалцаа авч хамтран ажиллаж байна. /2оноо/

- A. Азийн хөгжлийн банк
- B. Дэлхийн худалдааны байгууллага
- C. Олон Улсын Валютын сан
- D. Европын холбоо
- E. Дэлхийн банк

45. Дараах график, диаграммыг ажиглаж ямар уур амьсгалтай газар нутаг болохыг сонгоно уу. /2оноо/

- A. Балканы (Пелопоннес) хойг, Грек
- B. Лена, Яны сав газар, ОХУ
- C. Сахелийн цөл, Чад улс
- D. Патагоны бэгэлцэг, Аргентин улс
- E. Калифорни - Сан Франциско, АНУ



46. Ойн ашиглалт нь хөрсний доройтлын гол шалтгаан нь болж буй бүс нутаг аль нь вэ? /2оноо/

- A. Хойд Америк
- B. Ази тив
- C. Төв Америк
- D. Австрали далайн орнууд
- E. Өмнөд Америк

16. Протестант шашныг шүтдэг бүс нутаг аль нь вэ? /1оноо/

- A. Өмнөд Европ
- B. Австрали далайн
- C. Зүүн Европ
- D. Төв Африк
- E. Өмнөд Америк

17. Хөвсгөл аймгийн нутагт оршихорд нь 192 сая тн фосфоритын хүдрийн нөөцтэй. /1оноо/

- A. Гурван булаг
- B. Бүрэнхаан
- C. Өндөр цагаан
- D. Төмөртэйн Овоо
- E. Могойн гол

18. Аутсорсинг - Гадаад нөөцийн судалгаа, шинжилгээ, шинэ технологи буюу үйлдвэрлэлийн дөрөвдөгч салбарт хамаарагдах ойлголтыг олно уу. /1оноо/

- A. Худалдаа хийх
- B. Зах зээлээ өргөжүүлэх
- C. Татварын хөнгөлөлт эдлэх
- D. Зар сурталчилгаа явуулах
- E. Хөрөнгө оруулалт хийх

19. Нарны хэт ягаан туяаны хорт үйлчлэлээс дэлхийг аль нь хамгаалдаг вэ? /2оноо/

- A. Агаар мандал
- B. Үүлний давхраа
- C. Соронзон орон
- D. Хийн мандал
- E. Озоны давхарга

20. Дараах томъёоны асуултын тэмдгийн оронд тохирох үгийг сонгоно уу. /2оноо/

- A. Насанд хүрээгүй ажиллагсад
- B. Нас хэтэрсэн ажиллагсад
- C. Хүмүүн капитал
- D. Бүртгэлтэй ажилгүйчүүд
- E. Эдийн засгийн идэвхитэй хүн ам

Ажилгүйчүүд + Ажиллагсад = ?

21. Говьсүмбэр аймаг нь 2001 онд УИХ-аар батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-аар эдийн засгийн аль бүсэд багтах вэ? /2оноо/

- A. Баруун бүс
- B. Хангайн бүс
- C. Төвийн бүс
- D. Зүүн бүс
- E. Улаанбаатарын бүс

22. Уулын спортын тамирчин нь 6000 м өндөр оргилд авирахын тулд ямар улсад очих нь зөв бэ? /2оноо/

- A. Бразил
- B. Мексик
- C. Афганистан
- D. Кени
- E. Шинэ Зеланд

23. Төвдөө их даралттай, цагийн зүүний дагуу доош чиглэлтэй агаарын хуйлраа хөдөлгөөнийг.....гэнэ. /2оноо/


- A. Дулаан фронт
- B. Циклон
- C. Хүйтэн фронт
- D. Агаарын масс
- E. Эсрэг циклон

24. Баруун Африкийн далайд гарцгүй орнуудын үргэлжилсэн бүсэд багтах улсуудыг олоорой. /2оноо/

- A. Этиоп, Чад
- B. ТАБНУ, Мали
- C. Мали, Нигер
- D. Чад, Буркина-Фасо
- E. Мавритани, Уганда

25. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн бүдүүвчийг гүйцээж нөхөөрэй. /2оноо/

- A. 365 сум, 2336 баг
- B. 292 сум, 1956 баг
- C. 530 сум, 954 баг
- D. 465 сум, 2565 баг
- E. 329 сум, 1568 баг



26. Дэлхийн хамгийн том хоолой аль нь вэ? L - 1670 км , D - 422 км /2оноо/

- A. Данийн хоолой
- B. Девисийн хоолой
- C. Мозамбикийн хоолой
- D. Малаккийн хоолой
- E. Дрейкийн хоолой


27. Африк тивийн хаант засаглалтай улсыг сонгоно уу. /2оноо/

- A. Тунис
- B. Жибути
- C. Марокко
- D. Эритрей
- E. Малави

39. Архангай болон Баянхонгор аймгийн хилийг дамнан орших нурууг сонгоно уу. /2оноо/

- A. Тарвагатай
- B. Хөх сэрх
- C. Хангай
- D. Хэнтий
- E. Булнай

40. Бүдүүвч дэх 1 ба 2 байршилд тохирох тивийн нэрийн утгыг сонгоно уу. /2оноо/



- A. Нар ургах зүг, Нар жаргах зүг
- B. Нар ургах зүг, Хүйтэрдэггүй газар
- C. Хүйтэрдэггүй газар, Нар жаргах зүг
- D. Эсрэг хойд туйл, Өмнөд эх газар
- E. Өмнөд эх газар, Хүйтэрдэггүй газар

41. Салхины хурдыг тодорхойлох бол аль багажийг ашиглах вэ? /2оноо/

- A. Анемометр
- B. Курвиметр
- C. Алтиметр
- D. Теодолит
- E. GPS

33. Чи нэн ховор ан амьтан болох бөхөнг үзэхээр бол хаашаа явах вэ? /2оноо/

- A. “Монгол дагуур”- ын ДЦГ
- B. “Шарга-Манханы тал” БНГ
- C. “Их Нарт”- ын БНГ
- D. “Хөх Сэрх”- ийн ДЦГ
- E. “Хан Хэнтий” ДЦГ

34. Европын холбоонд гишүүнээр элсээгүй улсуудыг олоорой. /2оноо/

- A. Испани, Финланд
- B. Франц, Герман
- C. Серби, Швейцарь
- D. Бельги, Нидерланд
- E. Ирланд, Грек

35. Жижиг ширхэгтэй цас болон шиврээ бороо ордог, манантай төстэй нэг маягийн саарал өнгөтэй үүлийг олоорой. /2оноо/

- A. Борооны давхраат
- B. Өндрийн давхраат
- C. Борооны бөөн
- D. Давхраат
- E. Давхраат бөөн



36. Нийт цахилгаан эрчим хүчнийхээ 90% илүүг ДЦС-аас гарган авдаг улсуудыг сонгоно уу. /2оноо/

- A. Нидерланд, БНХАУ
- B. Мексик, Польш
- C. Румын, БНХАУ
- D. ӨАБНУ, Нидерланд
- E. Польш, Энэтхэг

37. Хойд Америкийн эх газрын хамгийн нам цэг (-89м) аль нь вэ? /2оноо/

- A. Миссисипийн нам газар
- B. Сент-Чарльз хошуу
- C. Үхлийн хөндий
- D. Солтон-Си нуур
- E. Флоридын хойг

38. Хойд мөсөн далайн өмнөд захын булан болон улсыг сонгоно уу. /2оноо/

- A. Гүдзон(Жеймс)-ы булан, Канад улсын эрэг
- B. Мелвиллийн булан, Гренланд арал
- C. Хунаблоуи булан, Исланд улсын эрэг
- D. Онегийн булан, Орос улсын эрэг
- E. Баруун фьордын булан, Норвеги улсын эрэг


28. Амазонк мөрний мөнх ногоон (борооны) чийглэг ойг гэж нэрлэдэг. /2оноо/

- A. Прерий
- B. Сельвас
- C. Пампа
- D. Льянос
- E. Каатинг

29. Камбож улс нь 1914 онд аль улсын колони байсан бэ? /2оноо/

- A. Нидерланд
- B. Орос
- C. Бельги
- D. Испани
- E. Франц

30. Газрын зурагт байгалийн ямар бүс, бүслүүрийг 2 гэсэн цифрээр тэмдэглэсэн бэ? /2оноо/



- A. Хээрийн бүс
- B. Говийн бүс
- C. Уулын бүслүүр
- D. Цөлийн бүс
- E. Ойт хээрийн бүс

31. Урал хэлний бүлэгт багтах хэлээр аль улсуудын хүн ам ярьдаг вэ? /2оноо/

- A. Орос, Украин
- B. Чех, Молдав
- C. Норвеги, Швед
- D. Унгар, Финланд
- E. Беларусь, Орос

32. Габбро, диорит нь ямар чулуулаг вэ? /2оноо/

- A. Тунамал химийн
- B. Хувирмал
- C. Магмын бялхмал
- D. Тунамал органик
- E. Магмын шургамал